

ЕВРОПЫН ХОЛБОО-МОНГОЛ УЛСЫН ЧУХАГ ТҮНШ МӨН*Д.Уламбаяр****Удиртгал**

Дундад зууны үеэс үүсэлтэй Европын нэгдлийн үзэл санаа, дэлхийн II дайны дараа эрчээ авч 1947, 1949 оны БЕНИЛЮКС-ын гэрээ, 1951 онд Европын Нүүрс, Гангийн Нийгэмлэг, 1957 онд Европын Атомын Эрчим Хүчний Нийгэмлэг, Европын Эдийн Засгийн Хамтын Нийгэмлэг, 1992 онд Европын Холбоог байгуулахад гол түлхэх хүчийг өгсөн билээ.

Энэхүү асар том бүтэц 374 сая хүн амтай, нэг хүнд ногдох үндэсний нийт бүтээгдэхүүний дундаж нь 20000 ам.долларт хүрч, худалдааны нийт эргэлтээрээ дэлхийд 2-р байранд ордог, дэлхийн нийт үйлдвэрлэлийн 19.8%-г 2000 онд үйлдвэрлэсэн нь 20.4%-г үйлдвэрлэдэг АНУ-ын дараа хоёрдугаарт орох үзүүлэлт болжээ.

Европын Холбоог байгуулах тухай Маастрихтын 1992 оны гэрээний дагуу Европын Холбоо нь нэгдсэн гадаад бодлого, аюулгүй байдал, нэгдсэн зах зээл, валютын бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн нь Европын Холбоо дэлхийн эдийн засагт төдийгүй улс төрийн амьдралд нөлөө үзүүлж чадахуйц томоохон хүчин болохыг харуулж байна.

Үүний хамтаар 2002 оноос эхэлж Төв ба Зүүн Европын хэд хэдэн орон Европын Холбооны интеграцчилалд нэгдэх бодит үйл явц эхлэх гэж байна. Үүнээс үзэхэд Европын Холбоо шинэ гишүүдээр эгнээгээ тэлж, дотоодын интеграцчиллыг гүнзгийрүүлж мөн өөрийн байр суурийг улам бэхжүүлэх боллоо. Дэлхийд эзэлж буй байр суурь, гүйцэтгэж буй үүрэг нь улам бүр өсөн нэмэгдэж байгаа Европын Холбоотой Монгол Улс харилцаа, хамтын ажиллагаагаа сайтар хөгжүүлэх нь манай улсын хувьд гадаад бодлогын чухал чиглэлийн нэг болж байна.

Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд “Монгол Улсын гадаад бодлогын хоёр дахь чиглэл бол АНУ, Япон, ХБНГУ зэрэг өрнө, дорны өндөр хөгжилтэй гүрнүүдтэй найрсаг харилцааг хөгжүүлэх явдал мөн. Үүний хамт Энэтхэг, БНСУ, Тайланд, Сингапур, Турк, Дани, Финлянд, Австри, Швед, Швейцари зэрэг оронтой найрсаг харилцаа хөгжүүлж, тэдгээрийн эдийн засгийн болон бусад бодит сонирхлыг Монголд бий болгон зохистой түвшинд хүргэх бодлого баримтална.” гэж заасан билээ. Энэ нь үндсэндээ гадаад бодлогын 6 чиглэл дотор хөрш хоёр орны дараа орох хоёр дахь чиглэл болж байгаа билээ. Өөрөөр хэлбэл манай улс энэ чиглэлд ихээхэн ач

* Д.Уламбаяр - МУИС-ийн Олон улсын харилцааны сургуулийн багш, доктор (Ph.D)

холбогдол өгдгийг нотолж байна. Монгол Улс ХБНГУ, Англи, Франц, Дани, Финлянд, Швед, Нидерланд, Бельги, Итали зэрэг өрнийн өндөр хөгжилтэй орнуудтай хоёр талын төвшинд төдийгүй Европын Холбооны хүрээнд харилцаа, хамтын ажиллагаагаа хөгжүүлж байгаа бөгөөд цаашид улам дэлгэр хөгжүүлэх шаардлагатай болжээ.

1980-аад оны сүүлээс ЗХУ-д өрнөсөн улс төрийн шинэ сэтгэлгээ, өөрчлөн байгуулалт Төв болон Зүүн Европын социалист орнуудад нөлөөлсөн нь "Европ-нийтийн орон гэр" үзэл санааг дахин дэвшүүлэн тавих нөхцөлийг бүрдүүлсэн билээ. Энэ үйл явц ч ЕЭЗХН, ЭЗХТЗ-ийн хооронд албан ёсны харилцаа тогтоох шимтэй хөрс нь болсон байна. Анх 1973 онд ЭЗХТЗ-ийн нарийн бичгийн дарга ЕЭЗХН-ийн Сайд нарын Зөвлөлийн даргатай Копенгаген хотод уулзаж хоёр байгууллагын хооронд албан ёсны хэлэлцээ хийж эхлэхийг санал болгож байжээ. 1976 онд хоёр тал хамтран ажиллах тухай гэрээний өөр өөрсдийн төслийг үйлдэж санал солилцсон боловч тодорхой тохиролцоонд хүрч чадаагүй ажээ.

1985 онд ЭЗХТЗ-өөс хоёр байгууллагын хооронд яриа хэлэлцээг сэргээх санал тавьсны дараа 1986, 1987 онд шинжээчдийн уулзалт болж ЭЗХТЗ, ЕЭЗХН-ийн хооронд албан ёсны харилцаа тогтоох тухай тунхаглалын төсөл хэлэлцжээ. Улмаар 1988 оны зургадугаар сарын 25-нд Люксембург хотод Хамтарсан Тунхаглал гарын үсэг зурснаар хоёр байгууллагын хооронд албан ёсны харилцаа тогтсон юм. Үүний дараа хамтын ажиллагааны тодорхой чиглэлүүдээр яриа, хэлэлцээ эхэлсэн байна. Тухайлбал:

Хүрээлэн буй байгаль орчныг хамгаалах салбарт: байгаль орчныг хамгаалах Европын нэгдсэн механизм бий болгох, энэ чиглэлд хүч чармайлтаа нэгтгэж, ус, хөрс, агаарт хорт бодис хуримтлагдаж болох хамгийн доод хэмжээг тогтоох, байгалийн гамшгийг урьдчилан мэдээлж байх олон улсын найдвартай систем байгуулах, үйлдвэрийн томоохон ослын хор уршгийг арилгах хамтарсан арга хэмжээг төлөвлөх, хаягдалгүй техник, технологи боловсруулж, нэвтрүүлэхэд хамтран ажиллах,

Шинжлэх ухаан, техникийн салбарт: Өрнөдөөс ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудад нийлүүлдэг технологийн 70 хувь нь ЕЭЗХН-ийн орнуудынх байв. Иймээс цаашид энэ чиглэлээр харилцаагаа өргөжүүлж, ЕЭЗХН-ийн гишүүн орнуудын хэрэгжүүлж байгаа "Эврика" хөтөлбөр, ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын ШУТ-ийн дэвшлийн Цогцолбор программын эн тэргүүний зорилтуудыг хэрэгжүүлэхэд хүч чармайлтаа төвлөрүүлэх, хамтарсан үйлдвэр, аж ахуйн нэгж байгуулах, хоёр талын үйлдвэрүүдийн хооронд шууд харилцаа, хамтын ажиллагаа тогтоон хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх,

Стандартчилалын салбарт: Стандартчилалын ялгаа, зөрүү нь ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудаас ЕЭЗХН-ийн орнуудад бүтээгдэхүүнээ гаргахад

саад тогтор болдог байв. Иймээс ЭЗХТЗ, ЕЭЗХН-ийн стандарт, код, индекс, барааны ангиллыг ойртуулж жигдрүүлэх, **Статистик:** ЭЗХТЗ, ЕЭЗХН-ийн хооронд эдийн засгийн харилцаа хөгжүүлэхэд статистикийн тоо, баримт харилцан солилцох, харьцуулан дүн шинжилгээ хийх нь чухал ач холбогдолтой байв. Иймээс харьцуулж болохуйц тоон үзүүлэлт боловсруулж харилцан мэдээлж байх,

Тээвэр болон эрчим хүчний салбарт: нийт Европын нэгдсэн систем байгуулах нь чухал асуудал болсон байна. Түүнчлэн эрчим хүчний уламжлалт түүхий эдээс гадна нар, салхи зэрэг байгалийн сэргээгдэх нөөцийг ашиглах замаар эрчим хүчний шинэ эх сурвалжийг өргөжүүлэх, цөмийн эрчим хүчийг хөгжүүлэхийн зэрэгцээ түүний аюулгүй байдлыг хангах, энэ талаар мэдээлэл солилцох, цөмийн хаягдлыг устгах орчин үеийн техник, технологи хамтран боловсруулах зэрэг олон асуудал хамрагдаж байв. Энэ салбарт хамтын ажиллагаа хөгжүүлэх арга, хэлбэрийг тодорхойлох нь бэрхшээлтэй байсан боловч талууд байр сууриа ойртуулж, санал нэгдмэл байгаа асуудалдаа түшиглэн харилцан буулт хийж, нийт Европын эрх ашгийг илүүтэйд эрхэмлэх нь зүйтэй гэж үзсэн байна.

Гэхдээ ЕЭЗХН-ийн удирдлага ЭЗХТЗ-тэй харилцаагаа өргөжүүлэхээсээ илүү гишүүн социалист орнуудтай хоёр талын харилцааны эрх зүйн үндсийг буй болгож, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд онцгой ач холбогдол өгч байсан юм¹. Тиймээс ч 1988 оны наймдугаар сард ЕЭЗХН ЗХУ, БНАГУ, Унгар, Болгар дараахан нь Польш, БНСЧСУ-тай дипломат харилцаа тогтоожээ.

Гадаад, дотоод өөрчлөлтийн үйл явцтай холбогдон 1980-аад оны сүүлээс Монгол улсад гадаад харилцааны салбарт багагүй дутагдал оршиж байгааг шүүмжилж эхэлсэн билээ.

Улс орны дотоод амьдралын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд гадаад харилцааны өргөн боломжийг бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байгаа, гадаад улс төр, гадаад эдийн засгийн бодлогын харилцан шүтэлцээ, цогц байдлыг зөв хослуулах, олон улсын байдал болон гадаад харилцааны асуудалд нарийн судалгаа, дүн шинжилгээтэй хандах явдал дутагдалтай байгааг шүүмжлээд үзэл суртал, бусад ялгааг шалтаг болохгүйгээр өндөр хөгжилтэй өрнөдийн орнуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг тогтоон хөгжүүлэх нь цаг үеийн бодит байдалд нийцсэн олон улсын харилцааны ирээдүйтэй хандлага болсныг цохон тэмдэглэсэн юм. Энэхүү гадаад, дотоод таатай нөхцөл нь Монгол улс 1989 оны 8-р сард ЕЭЗХН-тэй дипломат харилцаа тогтоох бололцоог олгожээ.

¹ Учир нь ЭЗХТЗ бүтэц, зохион байгуулалт, санхүүжилтийн хувьд цаашид оршин тогтнох ирээдүйгүй болсонтой юуны өмнө холбоотой байв. Тэгээд ч социалист систем задарснаар 1991 оны долоодугаар сарын 28-нд ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын төлөөлөгчид түүнийг татан буулгах тухай протоколд гарын үсэг зурсан юм.

Европын Холбоо - Монгол Улсын чухаг түнш мөн

ЕЭЗХН-тэй дипломат харилцаа тогтоохоос өмнө Монгол улсын экспорт, импортын нэгдлүүд нийтийн зах зээлийн гишүүн зарим улс оронтой тухайлбал, Англи, Франц, ХБНГУ, Итали, Бельги, Австри зэрэг улсуудтай 1960-аад оноос худалдаа хийж эхэлсэн нь харилцааг хөгжүүлэх аятай дэвсгэр болсныг тэмдэглэх хэрэгтэй.

Монгол Улс социалист үзэл суртлын хүлээсний улмаас Европын Холбоотой нэлээд хойхно дипломат харилцаа тогтоосон хэдүй боловч түүнээс хойш даруй 10 гаруй жил өнгөрчээ. Энэхүү багагүй хугацааны хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг судлах, дүгнэх шаардлагатай болжээ. Нөгөөтэйгүүр Монгол Улс Европын Холбоотой харилцаа, хамтын ажиллагаагаа хөгжүүлэхэд ихээхэн ач холбогдол өгч байгааг дээр тэмдэглэсэн. Учир нь:

- Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд Европын Холбооны орнуудыг гадаад бодлогынхоо хоёрдахь чиглэл мөн гэж заасан;

- Европын Холбоо нь Монгол Улсын гуравдахь том хөрөнгө оруулагч мөн;
- Европын Холбоо нь үзүүлж буй зээл, тусламжийн хэмжээгээрээ Монгол

Улсын гуравдахь том хандивлагч;

- Европын Холбоо нь Монгол Улсын худалдааны гуравдахь том түнш мөн;
- Европын Холбоо нь эдийн засгийн төдийгүй улс төр, аюулгүй байдлын чухаг

түнш мөн. Учир нь Европын Холбоо нь Монгол Улсад ардчилал, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах, зах зээлийн эдийн засагт шилжих үйл явцыг анхнаас нь дэмжин тусалж мөн Монгол улсын цөмийн зэвсэггүй статусыг хүндэтгэж ирсэн. Энэ утгаараа Монгол Улсын бодлогыг дэмжиж байгаа билээ.

Монгол Улс, Европын Холбооны харилцаа, хамтын ажиллагаа 1989 оноос хойш улс төр, эдийн засаг, хөгжлийн тусламж гэсэн үндсэн 3 чиглэлээр хөгжиж байна гэж үзэж болох юм.

Европын Холбоо нь Маастрихтын гэрээнд заасан Хөгжлийн хамтын ажиллагааны бодлогыг хэрэгжүүлэхдээ хөгжиж буй орнуудад тусламж, дэмжлэг үзүүлнэ гэж заасан байдаг. Үүний үндсэн дээр бусад хөгжиж буй орнуудын нэгэн адил Монгол Улстай дипломат харилцаа тогтоож, харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд анхаарч байна.

1980-аад оны сүүлч, 90-ээд оны эхнээс социалист систем задран унаж социалист орнууд хөгжлийнхөө зөв голдрилд орсон нь дэлхийн ялангуяа Европын энх тайван, аюулгүй байдалд ихээхэн чухал ач холбогдолтой байв. Ийм учраас Европын Хамтын Нийгэмлэг

хуучин социалист орнуудыг ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжихэд нь онцгой анхаарч, тусламж дэмжлэг үзүүлэх бодит шаардлагын улмаас ЕЭЗХН тэдэнд техникийн тусалцаа үзүүлэх бие даасан хөтөлбөрийг буй болгожээ. Хуучин социалист орны нэг болох Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт амжилттай шилжиж, ардчилал, хүний эрх, эрх чөлөөг жинхэнэ ёсоор баталгаажуулах бодлого явуулсан нь Европын Холбоо Монгол Улстай харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх нэг сэжим нь болсон.

Дурьдсан дээрхи хүчин зүйл бол Европын Холбоо манай улстай харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх зарчмын хувьд чухал үндэслэлүүд юм. Дурьдах гэж буй дараахи хүчин зүйл бол Европын Холбооны Монгол Улс дахь бодит сонирхлыг илэрхийлж буй хамгийн чухал бөгөөд алсдаа үлэмж учир холбогдолтой Монгол Улсын газар зүйн байрлал юм. Европын Холбооны Комиссар Ханс Ван ден Брук Монгол Улсад 1996 оны 9-р сард айлчлах үеэрээ хэлэхдээ: "Монгол Улс газарзүйн чухал байрлалтай тул Европын Холбоо, Монгол Улстай харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх сонирхолтой байдаг" гэжээ. Эндээс үзэхэд Орос, Хятадын асар том зах зээлд нэвтрэн орох түшиц газар хэмээн Монгол Улсыг Европын Холбоо сонирхож байгаа нь тодорхой байна. Түүнчлэн Монгол улс Зүүн Хойд Азийн бүс нутгийг Европын Холбоотой холбож буй гүүр гэдгийг тэмдэглэвэл зохино.

Манай улс Европын Холбоотой харилцаа, хамтын ажиллагааг бат бэх харилцан ашигтайгаар хөгжүүлэхийн тулд Европын Холбооны Монгол Улс дахь бодит сонирхлыг бий болгож дэмжих учиртай. Манай Улсын газар зүйн байрлалын онцлог байдлыг ашиглах боломжийг Европын Холбоонд олгохын тулд хөрш хоёр оронтойгоо болон Зүүн Хойд Азийн сав нутагтай дэд бүтцийн сүлжээгээ хөгжүүлэхэд идэвхи санаачлагатай ажиллах хэрэгтэй.

Монгол улсаас Европын Холбоотой хамтран ажиллах ихээхэн ирээдүйтэй суваг бол АСЕМ-д гишүүнээр элсэн орох явдал бөгөөд АСЕМ нь Ази-Европын олон талт хамтын ажиллагааны бодит үйл явц мөн билээ.

Улс төрийн харилцаа

Дипломат харилцаа тогтоосноос хойш Монгол улс 1992 оноос Европын Холбооны төв Брюссель хотноо Элчин Сайдын Яамаа нээн ажиллуулж байна. Европын Холбооны Бээжин дэх Элчин сайд манай улсыг хавсран ажилладаг бөгөөд Европын Холбооноос Монгол Улсад суух Элчин сайд Эндимон Вилкинсон 1995 онд Итгэмжлэх жуух бичгээ барьжээ.

Монгол Улс, Европын Холбооны улс төрийн харилцаа нь парламент хоорондын хүрээнд идэвхтэй хөгжиж байгаа бөгөөд

өнгөрөгч хугацаанд Монгол Улсын Их Хуралд Монгол-Европын Холбооны харилцааны бүлэг, Европын Парламентэд Төв Азийн тусгаар улсууд болон Монгол Улстай харилцах бүлэг үйл ажиллагаагаа явуулсаар ирлээ. Хоёр талын парламент төлөөлөгчдөө харилцан айлчлуулж, туршлага солилцох, санал бодлоо хуваалцах хэлбэрээр голчлон үйл ажиллагаагаа явуулж байна.

1993 онд Монгол Улсын Их Хурлын дарга Н.Багабанди Европарламентад, 1995 онд УИХ-ын гишүүн, ажилтны төлөөлөгчид туршлага судлахаар Европарламентад, 1995 онд Европарламентын Төв Ази, Монгол Улстай харилцах бүлгэмийн дарга К.Раблес Пикер тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсын Их Хуралд, 1996 онд УИХ-ын дарга Р.Гончигдорж Европарламентад, 1997 онд УИХ-ын гишүүн, УИХ дахь Монгол-Европын харилцааны бүлгийн орлогч дарга О.Энхтуяа тэргүүтэй төлөөлөгчид Европарламентад, 1998 онд Европарламентын Дундад Ази Монголтой харилцах бүлгэмийн дарга Филипе Камесон Асенсию Монголд тус тус айлчилжээ.

Мөн үүнээс гадна Европын Холбоо ба Монгол Улсын Төр, Засгийн тэргүүн болон Сайд нарын дээд хэмжээний айлчлалууд нэлээд зохиогдсон байна. 1992 онд Монгол Улсын ерөнхий сайд С.Бямбасүрэн Европын Холбоонд, 1995 онд Монгол Улсын ерөнхийлөгч П.Очирбат Европын Холбоонд, 1996 онд ЕХ-ны комиссар Ханс Ван ден Брук Монгол Улсад, 2000 оны 2-р сард Монгол Улсын Гадаад Харилцааны сайд Н.Туяа, 2001 оны 1-р сард Монгол Улсын ерөнхий сайд Н.Энхбаяр ЕХ-нд тус тус айлчилж, багагүй асуудлыг шийдэж, хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг тодорхой хэмжээгээр ахиулсан ач холбогдолтой алхмууд болов.

1992 онд ерөнхий сайд С.Бямбасүрэн Европын Холбоонд айлчлахдаа “Монгол Улс, ЕЭЗХН-ийн Худалдаа, Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Хэлэлцээр”-т, 1995 онд ерөнхийлөгч П.Очирбат мөн айлчлалынхаа үеэр “Сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүн болон хувцас худалдаалах тухай Монгол Улс, ЕЭЗХН-ийн хэлэлцээр”-т тус тус гарын үсэг зурсан байна. Европын Холбооны Комиссар Ханс Ван ден Брук манай улсад айлчлаад, манай талын бодит байдалтай газар дээр нь танилцан, Тасисын төслүүд илүү үр дүнтэй хэрэгжиж байгааг онцлон тэмдэглэсэн байв. ГХ-ны сайд Н.Туяа, ерөнхий сайд Н.Энхбаяр нар айлчлалынхаа үеэр Европын Холбооны Тасис хөтөлбөрийн дагуу Монгол Улсад 2000-2006 онд үзүүлэх тусламжийн хүрээнд хамтын ажиллагааны дараахь салбаруудад тухайлбал хувийн секторыг дэмжих, эдийн засгийг хөгжүүлэх, шилжилтийн үеийн нийгмийн үр дагаварыг шийдвэрлэхэд тусалцаа үзүүлэх, хөдөөгийн эдийн засгийн хөгжлийг дэмжихэд тэргүүлэх ач холбогдол өгч байгаагаа илэрхийлж мөн Монголоос Европын Холбоонд мах экспортлох боломжийг нээх, сүлжмэл барааны гаалийн тарифыг

бууруулах, Европын хөрөнгө оруулалтын банкнаас хөнгөлөлттэй зээл авах, зудын бэрхшээлийг гэтлэн давахад тусламж үзүүлэх зэрэг асуудлыг хөндөн ярилцсан байна.

Монгол Улс, Европын Холбооны харилцаа, хамтын ажиллагааг тухайлан улс төрийн харилцааг шинэ шатанд гаргахын тулд Европын Холбоотой “Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийг байгуулахаар багагүй чармайлт гаргаж байгаа бөгөөд Европын Холбооны тал манай улстай ийм хэлэлцээр байгуулахад одоогоор бэлэн биш байгаа бололтой. Монгол Улс “Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээр” (Partnership and Cooperation Agreement)-ийг Европын Холбоотой байгуулбал хоёр талын хамтарсан зөвлөл, хамтарсан хороо, парламентын хамтарсан хорооны хуралдааныг жил бүр зохион байгуулж улмаар улс төрийн байнгын уулзалтын механизм бий болж, улс төрийн харилцааг гүнзгийрүүлэх бололцоотой болох юм.

1992 оны “Худалдаа, Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Хэлэлцээр”-ийн үндсэн дээр байгуулагдсан Европын Холбоо ба Монгол Улсын Хамтарсан Хорооны 1994 оны 10-р сард Брюссельд болсон II хуралдааны үеэр манай төлөөлөгчид хоёр талын харилцааг илүү ойр дотно хөрсөн дээр хөгжүүлэх эрмэлзлэлийн үндсэн дээр Европын Холбоотой “Түншлэл, Хамтын Ажиллагааны Хэлэлцээр” байгуулах талаар хөндөхөд, хамтын ажиллагаа эрчимжихийн хирээр тийм боломж нээгдэж болно гэж үзэж байгаагаа Европын Комиссын орлогч дарга Ханс Ван ден Брук илэрхийлжээ. 1996 оны 4-р сард Улаанбаатар хотноо болсон Монгол Улс, Европын Холбооны хамтарсан хорооны III хуралдааны үеэр Европын Холбоо нь одоогоор Монгол Улстай Түншлэлийн хэлэлцээр байгуулахад бэлэн биш байгаа нь харагдаж байв. 1997 оны 11-р сард Брюссельд болсон уг хамтарсан хорооны IV хуралдаан дээр Европын Холбоо нь Монгол Улстай Түншлэлийн хэлэлцээр одоогооро байгуулах шаардлагагүй гэж үзэж байгаагаа тайлбарлаж, Монгол Улс ба Европын Холбооны хооронд байгуулсан 1992 оны “Худалдаа, Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Хэлэлцээр” хоёр талын харилцааны эрх зүйн үндсийг бүрэн утгаар нь бүрдүүлж чадаж байна. Европын Холбоо нь Монгол Улсыг улс төрийн талаар ямагт дэмждэг бөгөөд хоёр талын хооронд улс төрийн бүх шатанд яриа хэлэлцээ явагдаж буй зэргийг иш үндэс болгосон байна.

Монгол улс дэлхийд тэргүүлэх хөгжилтэй өрнөдийн орнуудыг эгнээндээ нэгтгэдэг ЕЭЗХН-тэй 1989 оны 8-р сарын 1-нд тогтоосон дипломат харилцаан дээрээ үндэслэн, харилцаагаа цаашид бодитойгоор хөгжүүлэх, түүний үр шимийг хүртэх бодит нөхцлийг бүрдүүлэх зорилгоор IXудалдаа, Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Хэлэлцээр”-т 1992 оны 6-р сард гарын үсэг зурсан билээ.

*ЕХ нь ОХУ-тай ийм хэлэлцээг 1994.06.24-нд байгуулж 1997.12.01-нээс хүчин төгөлдөр болсон байна.

Энэ хэлэлцээрийн гол ач холбогдол нь улс орны хамгийн чухал салбар эдийн засаг, худалдаа, хөрөнгө оруулалтын салбарт ЕЭЗХН-тэй хамтын ажиллагааг хөгжүүлж, тусламж дэмжлэгийг авах эрх зүйн үндсийг баталгаажуулж өгсөнд оршино. Нөгөө талаар энэ хэлэлцээр хоёр талын харилцааны эрх зүйн үндсийг тодорхойлж өгсөн ач холбогдолтой. Уг хэлэлцээр 4 бүлэг, 16 зүйлтэй, 1993 оны 3-р сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон байна. Хэлэлцээрийн гол зорилго нь хоёр тал тус тусын эрх мэдлийн хүрээнд Европын Холбоо, Монгол улсын аж үйлдвэр, ХАА-н хөгжлийг ахиулах, эдийн засгийн харилцаагаа өргөтгөн бэхжүүлэх, шинжлэх ухаан, технологийн дэвшлийг түргэтгэх, хангамжийн шинэ эх үүсвэр, шинэ зах зээл нээж бий болгох, эдийн засгаа хөгжүүлэн, амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд тус дэм болох явдал юм. Энэхүү зорилгыг биелүүлэхийн тулд хэлэлцэн тохирогч хоёр тал эдийн засгийн хамтын ажиллагааг бүх талаар тухайлбал дараахи салбарт хөгжүүлэхээр тохирчээ. Үүнд:

- аж үйлдвэр, уул уурхай,
- хөдөө аж ахуй, ойн аж ахуй,
- шинжлэх ухаан, технологи,
- эрчим хүч, харилцаа холбоо,
- орчныг хамгаалах,
- жуулчлал,
- оюуны болон аж үйлдвэрийн өмч, стандарт,
- статистик зэрэг чиглэл болно.

Дурдсан зорилгыг хэрэгжүүлэхийн тулд хоёр тал тус тусын хууль, эрх зүйн бодлогын хүрээнд харилцан ашигтай, ахиу хөрөнгө оруулалт хийхийг хөхүүлэн дэмжиж тус дөхөм үзүүлж байхаар тохиролцсон байна. ЕЭЗХН хөгжиж буй орнуудад үзүүлдэг тусламжийн хөтөлбөрийнхөө хүрээнд "Монгол Улсыг дэмжихэд чиглэсэн санхүүгийн болон техникийн хамтын ажиллагаагаа өргөжүүлнэ" гэж заажээ.

Хэлэлцээрийн дагуу ЕЭЗХН-ийн 1983 оны гаалийн нэгтгэсэн номенклатур дахь Монгол улсаас гаралтай Хамтын Нийгэмлэгийн бүс нутагт чиглэгдсэн импортын барааны тоо хэмжээний хязгаарлалтыг хүчингүй болгож, хэлэлцэн тохирогч хоёр тал Монгол Улс ба ЕЭЗХН-ээс гаралтай нүүрс, гангийн бус бүх төрлийн бараа, бүтээгдэхүүнийг худалдаалахад үндэстний нэн тааламжтай нөхцөлийг харилцан олгохоор тохиролцсон байна. Хоёр тал худалдаа хийж, үйлчилгээ үзүүлэхдээ зах зээлийн үнэ ханшийг баримталж, бараа гүйлгээнийхээ төлбөрийг тус тусын холбогдох хууль тогтоомжийн дагуу чөлөөтэй хөрвөдөг валютаар хийхээр болжээ.

Мөн уг хэлэлцээрийг хэрэгжүүлэх нэг гол механизм болгож уг хэлэлцээрийн биелэлтийг хянаж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, санал, санаачлага дэвшүүлж байх үүрэг бүхий Монгол Улс, Европын

Холбооны Хамтарсан Хороог байгуулахаар шийдвэрлэсэн юм.

Энэ хорооны хамтарсан V хурал 2000 оны 12-р сард Улаанбаатар хотод хуралдлаа. Хамтарсан хороог Монгол Улс, Европын Холбооны төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, жилд нэг удаа Улаанбаатарт эсвэл Брюссельд ээлжлэн хуралдаж аль нэг талын хүсэлтийн дагуу харилцан тохиролцсоны үндсэн дээр ээлжит бус хурал хийж болох ба Хамтарсан хорооны хуралдааныг талууд ээлжлэн даргалах бөгөөд хорооны ажилд туслалцуулах үүднээс ажлын хэсэг байгуулж болно гэж тохиролцжээ. Хамтарсан хорооны чиг үүргийг тодорхойлохдоо:

- а. энэхүү хэлэлцээрийн биелэлтэнд хяналт тавьж, шалгаж байх, худалдааны эргэлтийн өөрчлөлт, эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн тусламжийн хэрэгжилтэнд хяналт тавих;
- б. энэ хэлэлцээрт хамрагдсан төрөл бүрийн салбарт бэрхшээл гарахаас урьдчилан сэргийлэх талаар холбогдох арга хэмжээг авч байх;
- в. худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлж, төрөлжүүлэхэд түлхэц өгөхүйц арга хэмжээ авч байх;
- г. хэлэлцээрт хамрагдсан салбаруудад холбогдох бөгөөд хоёр талын сонирхсон аливаа асуудлаар санал солилцож, санаа оноо дэвшүүлж байх гэжээ.

Энэхүү хэлэлцээрийг 5 жилийн хугацаатай байгуулсан бөгөөд хэлэлцээрийн хүчинтэй байх хугацаа дуусахаас 6 сарын өмнө хэлэлцэн тохирогч аль нэг тал түүнийг хүчингүй болгох тухай нөгөө талдаа бичгээр мэдэгдээгүй бол энэхүү хэлэлцээрийн хүчинтэй байх хугацаа нэг нэг жилээр аяндаа сунгагдах юм. Хэлэлцээрийн үр дүн нь: Нэгдүгээрт, ЕЭЗХН манай улсын өөрчлөлт шинэчлэлтийн үеийн бэрхшээлтэй байдлыг ойлгож, энэ шилжилтийг амжилттай даван туулах гэсэн манай талын чармайлтыг үнэлж, түүнд нь туслах, хөгжиж дэвжихэд нь тус дэм үзүүлэхээ илэрхийлснээр харагдаж байна. Уг хэлэлцээрийн оршил хэсэгт "...Монгол Улс ардчлалыг бэхжүүлж, эдийн засаг, нийгмийн дэвшлийг урагшлуулах үүднээс өөрийн нийгэм, эдийн засгийг өөрчлөн шинэчлэх талаар Монгол Улсын Засгийн газраас ихээхэн чармайлт гаргаж байгааг ЕЭЗХН-ийн Зөвлөл хүлээн зөвшөөрч, ... дор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиров" гэжээ. Энэ хэлэлцээрийн үр дүнд Монгол Улсыг эдийн засгийн хувьд төдийгүй улс төрийн хувьд ч дэмжигч нөлөө бүхий түнш нэмэгдсэн билээ.

Хоёрдугаарт, "Монгол Улс, Европын Комиссын хоорондын хамтын ажиллагаа, түүнчлэн энэ хэлэлцээр нь бүхэлдээ Монгол Улс, Европын Комиссын дотоод, гадаад бодлогын үндэс болсон ардчилсан зарчим, хүний эрхийг хүндэтгэх явдалд тулгуурлаж байгаа болно." гэж хэлэлцээрт заасан нь Монгол Улсын хувьд ардчилал, хүний эрхийн зарчмыг тууштайгаар хүндэтгэн сахих явдлыг улам батжуулан бэхжүүлэх бас нэг алхам болсон;

Гуравдугаарт, уг хэлэлцээрийн үр дүнд Монгол Улс нь ЕЭЗХН-ийн 15 оронд бараа, бүтээгдэхүүнээ экспортлох саад хязгаарлалтыг /Хамтын Нийгэмлэгийн гаалийн нэгтгэсэн номенклатурын XI бүлэгт заасан нэхмэл эдлэлийн хязгаарлалт, Зөвлөлийн 3120/83 дугаар журмын Хавсралт III заасан хязгаарлалт/ цуцлуулсан;

Дөрөвдүгээрт, манай улс ЕЭЗХН-ийн хөгжиж буй орнуудад үзүүлдэг тусламжийн хөтөлбөрт тодруулбал 1993 онд Европын Холбооны техникийн туслалцааны А/А хөтөлбөрт, 1994 оноос ТАСИС хөтөлбөрт энэхүү хэлэлцээрийн үр дүнд хамрагдах болсон юм.

Тавдугаарт, энэхүү хэлэлцээрийн бас нэг чухал үр дүн бол Монгол Улс, ЕЭЗХН-ийн хамтарсан хороог байгуулахаар тохиролцсон явдал байв. Хамтарсан хорооны хуралдаан нь хоёр талын төлөөлөгчид байнга уулзаж, хоёр талын нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдал, ололт, бэрхшээлээ харилцан ярилцаж, санаа оноогоо дэвшүүлж, асуудлыг боломжийнхоо хэрээр шийддэг байнгын уулзалтын механизм болдогоороо чухал ач холбогдолтой юм. Тухайлбал манай тал энэ үеэр нийгэм, эдийн засгийнхаа өнөөгийн байдал, хийж бүтээсэн зүйлээ Европын Холбооны талд танилцуулж, тэдэнд өөрсдийнхөө боломж, бололцоо, үнэн байдлыг ойлгуулахыг чармайж иржээ. Хамтарсан хороо өнгөрөгч хугацаанд нийт 5 удаа (1993, 1994, 1996, 1997, 2000 онуудад) хуралдаж, нэлээд олон асуудлыг дэвшүүлж, хэлэлцэн шийдвэрлэж, ажил хэрэг болгосон ба яригдсаар байгаа асуудлууд ч байгаа юм.

Монгол Улс ба Европын Холбооны худалдааны харилцаа

Монгол Улс ба Европын Холбооны худалдааны харилцаа хамтын ажиллагааны эрх зүйн үндэс нь 1993 онд хүчин төгөлдөр болсон "Монгол Улс, ЕЭЗХН-ийн Худалдаа, Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Хэлэлцээр" билээ. Уг хэлэлцээрт хоёр тал худалдааны харилцаанд үндэстний нэн тааламжтай нөхцөлийг харилцан олгоно гэж заасан нь Монгол Улс оролцогч бусад улсуудад олгодог худалдааны нөхцлөө Европын Холбоонд, Европын Холбоо нь Монгол Улсад ялгаварлан гадуурхалгүй тэгш эрхийн үндсэн дээр мөн нэгэн адил эдлүүлнэ гэдгийг илтгэж байна. Өөрөөр хэлбэл энэ нь барааг импортлон авахтай холбогдсон тус тусын дотоодын хууль журмаар зохицуулагдана гэсэн үг.

Европын Холбоо нь дотоодын үйлдвэрлэгчдийнхээ эрх ашгийг хохироохгүйн үүднээс нүүрс, ган, сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүний импортод тодорхой хэмжээний тоон хязгаарлалт тавьж дотоодын зах зээлээ хамгаалах бодлогыг баримталдаг тул эдгээр бүтээгдэхүүнийг худалдан авахтай холбогдуулж Европын Холбоо нь гуравдагч улс

оронтой тусгайлан хэлэлцээр байгуулдаг. Сүлжмэлийн хоёр талын хэлэлцээр нь давхар ДХБ-ын "Сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүн болон хувцасны тухай хэлэлцээр"-ээр зохицуулагдаж байдаг.

Манай улсын хувьд авч үзвэл Монгол Улс нь Европын Холбооны орнуудад нүүрс, ган экспортлодоггүй, харин сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүнийг экспортлодог бөгөөд энэ нь Европын Холбоонд экспортлож байгаа нийт бүтээгдэхүүний 10 орчим хувийг эзэлж байна. Монгол Улс ба Европын Холбооны сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүний худалдааг "Сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүн ба хувцас худалдаалах тухай Монгол Улс, ЕЭЗХН-ийн хоорондын 1995 оны хэлэлцээр"-ээр зохицуулж байдаг.

Монгол Улс ба Европын Холбооны худалдааны харилцаа улам бүр либеральчилагдаж байгааг тэмдэглэн хэлэх нь зүйтэй.

Манай улсын сүүлийн таван жилийн нийт худалдааны дүнг харьцуулж үзэхэд Европын Холбоотой 1995 оноос хойш жил тутам 100 гаруй сая ам.долларын худалдааг хийсэн байх бөгөөд энэ нь Европын Холбоо нь манай улсын хоёр хөршийн дараа орох худалдааны гуравдагч том түнш болохыг илтгэж байна.

Манай улсын Европын Холбооноос импортолсон барааны хэмжээ Европын Холбоонд экспортолсон хэмжээнээс ихэвчлэн давж байгаагаас импорт нь худалдааны нийт эргэлтийг тодорхойлсон шинжтэй байна. Өөрөөр хэлбэл манай улсын Европын Холбоотой хийж байсан худалдаа ихэвчлэн алдагдалтай байсныг харуулж байна. 2000 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр Европын Холбоотой хийсэн худалдаанд 12 сая ам.долларын алдагдалтай байна. Тиймээс манай улс Европын Холбооны хөнгөлөлтийн нөхцлийг өгөөжтэй ашиглаж экспортоо нэмэгдүүлэх боломжийг эрж хайх хэрэгтэй юм.

Эцэст нь тэмдэглэж хэлэхэд энэ өгүүлэлд хөрөнгө оруулалт, хөгжлийн тусламжийн асуудлыг оруулаагүй болно.

Ашигласан ном, материал:

1. Монгол улсын гадаад бодлогын хөх ном. УБ, 2000
2. Монгол Улс, ЕЭЗХН-ийн Худалдаа, Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Хэлэлцээр. УБ, 1992
3. "Тадаад Харилцаа" товхимол, ГХЯ, УБ, 1996-2000 оны дугаар
4. Танилцуулга, Монгол Улс, ЕХ-ны Хамтарсан хорооны II, III, IV, V хуралдааны дүнгийн тухай, ГХЯ
5. Монгол улсын статистикийн Мэдээлэл. УБ, 1998, 1999, 2000 он
6. Международные экономические отношения, под ред. В.Е.Рыбалкин, М, 1999
7. John Edelman Spero, The Politics of International Economic Relations, 4th edition, N.Y.1998
8. Borchardt K.D. European Integration. The origins and growth of the Euro-pean Union. Brussels, 1998